



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/560

Булган сум

**Хөрөнгө хүлээн авах,
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн УТ2401900345002 дугаартай гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө төсөл Булган-трактор хаман боогч” арга хэмжээний хүрээнд “Грийн капитал” ХХК-ийн нийлүүлсэн 1,557,360, 120 (нэг тэрбум таван зуун тавин долоон сая гурван зуун жаран мянга нэг хорин төгрөг 00 мөнгө) төгрөгийн үнэ бүхий 11 ширхэг дугуйт трактор болон 16 ширхэг хаман боогчийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Э.Уянга (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Одхүү (Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн захирал)


Г.Гантулга (Хүнс, хөдөө аж ахуйн газрын усны инженер)

Нарийн бичгийн дарга: Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

2. Гэрээнд заагдсан тоо хэмжээ, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, данс бүртгэлд авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (Т.Баттулга)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



0304010747